

## **Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Ёс зүйн дэд хорооны 2024 оны тайлан**

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд даргын 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 248 дугаар тушаалаар Ёс зүйн дэд хороог байгуулсан.

Ёс зүйн дэд хороо 2024 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр хуралдаж, “Ёс зүйн дэд хорооны хуралдааны дэг”, “Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г батлан үйл ажиллагаандаа Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан “Ёс зүйн дэд хорооны ажиллах журам”, Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ”-г баримтлан ажиллаж байна.

Ёс зүйн дэд хорооны үйл ажиллагааны хүрээнд 2023 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Засгийн газрын хүний нөөцийн газраас шинээр томилогдсон албан хаагчдад “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдэвт сургалтыг зохион байгуулж, төрийн албан хаагчийн ёс зүй, ёс зүйн нийтлэг хэм хэмжээний талаар болон үйл ажиллагаандаа баримтлах зөвлөмжийг өгсөн. 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдөр Улсын Их Хурлын Ёс зүй, дэгийн байнгын хороо, Ёс зүйн хорооноос хамтран зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтын агуулга ба хэрэгцээ” сэдэвт хэлэлцүүлэгт Дэд хорооны төлөөлөл оролцсон.

Түүнчлэн, 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Төрийн албан хаагчийн ёс зүйн сургалтыг нийт албан хаагчдын дунд зохион байгуулсан.

2024 онд тус хороо нь төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой нийт 2 гомдлыг бичгээр хүлээн авч, 1 гомдлыг хянан шалгаж, дүгнэлт гаргасан бөгөөд 1 гомдлыг харьяаллын дагуу холбогдох хороонд хүргүүлэхээр шийдвэрлэсэн байна. 2024 онд ирүүлсэн гомдол нь төрийн албан хаагчийн харилцаа, хандлагын зөрчилтэй холбоотой гомдол байсан бөгөөд Ёс зүйн дэд хороогоор гомдлыг хэлэлцэн, дүгнэлт гаргаж, дүгнэлтийг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлж танилцуулав.